



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 524

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө олж авах зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 435 дугаар хаалттай хорих анги, Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын албан ажлын хэрэгцээнд зориулан үйлдвэрлэлийн дотоод орлогоос 214,000,000.00 (хоёр зуун арван дөрвөн сая) төгрөгт багтаан 2 ширхэг автомашин худалдан авахыг зөвшөөрч, худалдан авах автомашины техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаарыг хавсралтаар тогтоосугай.


2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, бригадын генерал Ц.Амгаланбаяр болон тогтоолд заасан байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.



ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 11 дүгээр сарын 22 ны өдрийн
бдц дугаар тогтоолын хавсралт

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА
435 ДУГААР ХААЛТТАЙ ХОРИХ АНГИ, НИЙСЛЭЛИЙН ШҮҮХИЙН
ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗРЫН ХУДАЛДАН АВАХ АВТОМАШИНЫ
ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ, ҮНИЙН ДЭЭД ХЯЗГААР

Д/д	Автомашины техникийн үзүүлэлт	Тоо ширхэг	Худалдаж авах хөрөнгийн үнийн дээд хязгаар (төгрөг)	
			Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
1	Суудлын тоо 5, хөдөлгүүрийн багтаамж 4000 cc, туулах чадвар сайтай	2	107,000,000.00	214,000,000.00
	Нийт дүн		214,000,000.00 (хоёр зуун арван дөрвөн сая)	